



СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/61

Хуурч

Г Малд үзлэг ангилалт хийх ажлын Г  
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, Малын генетик нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, 18.2.3, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/68 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны А/168 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тариалангийн бүс нутагт үржүүлж буй малд үзлэг, ангилалт хийх ашиг шимийн үзүүлэлтийг тогтоох, баталгаажуулах, үржлийн хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгч, үхэр сүргийг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Алтанзориг  
(Сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: Ч.Алтанхуяг  
(Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

Гишүүдэд:  
М.Алтаннавч  
(Мал, эмнэлгийн тасгийн дарга)  
Д.Сонсонбаярлах  
(Оргих 1 дүгээр багийн Засаг дарга)  
Б.Ганзориг  
(Тийрэг 3 дугаар багийн Засаг дарга )

2.Тариалангийн бүс нутагт үржүүлж буй малд үзлэг, ангилалт хийх ашиг шимийн үзүүлэлтийг тогтоох, баталгаажуулах, үржлийн хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгч, үхэр сүргийг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх ажлыг технологийн хугацаанд үр дүнтэй зохион байгуулан хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Алтанзориг)-т даалгасугай.

3.Зохион байгуулсан ажлын тайланг 2022 оны 11 дүгээр сарын 01-ний дотор сумын Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Хөдөө аж ахуйн тасгийн дарга (Ч.Алтанхуяг)-т даалгасугай.



Ц.БАЯНБААТАР